

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

“Улсын бүртгэлийн байгууллага 2025 оныг “Төрийн бүтээмж, нийгмийн баталгааг хэрэгжүүлэх жил”-ийн хүрээнд хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Энержи прагон ХХК-тай уулзалт хийж тус хэлтсийн албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр байр захиалах, мөн аймгийн Засаг даргын орлогч Г.Марттай уулзан албан хаагчдыг түрээсийн орон сууцанд оруулах талаар саналыг тус тус хүргүүлсэн

Улсын бүртгэлийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу ар гэрт гачигдал тохиолдсон, албан хаагч, гэр бүлд нь нийт 4,380,000 төгрөгийн тусламж үзүүлсэн байна.

Тус хэлтсээс өндөр насны тэтгэвэрт гарсан 4 ахмадуудаа сар шинийн баярыг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, дэмжих ажлын хүрээнд тус хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй 2 албан хаагч нь байнгын эмчийн хяналтанд байдаг бөгөөд тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг. Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4 заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдрөөр олгодог. Мөн гэрээт ажилтан Д.Баярсайханы хүү хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд хүүгээ насан туршийн боловсролын сургуульд хүргэж өгөх, авахад нь зориулж ажлын цагт нь зохицуулалтыг хийн хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш эрхийг хангаж өгсөн.

УБЕГ болон бусад газраас хийсэн онлайн болон танхимийн сургалтууд

1. 2025 оны 1 дүгээр сарын 13 Татварын газраас Хяналт шалгалтын тасгийн Татварын улсан байцаагч Э.Мөнхгэрэл “Хувь хүний орлого албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт” сэдэвт сургалт.
2. ХУБ Э.Уранбилэг 2025 оны 01 дүгээр сарын 24-нд “Зөрчлийн нэгдсэн сангийн програмын шинэчлэлт” сургалтанд хамрагдсан.
3. Мэдээлийн тенхологийн ажилтан П.Азжаргал, бичиг хэргийн эрхлэгч Н.Цэндмаа 2025 оны 01 дүгээр сарын 31 өдөр ERP.E-mongolia.mn системийн цахим сургалтанд хамрагдсан.
4. УБЕГ-аас цахим сургалт 2025 оны 02 дугаар сарын 11 өдөр Авилгатай тэмцэх газрын комиссар Ц.Сэлэнгэ “Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтанд иргэний бүртгэлийн тасгийхан хамрагдсан.
5. УБЕГ-аас 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Хяналтын ахлах улсын байцаагч А.Мөнхцэцэг Иргэний 8 төрөл болон гадаад паспорт дээр анхаарах асуудал сэдэвт сургалт.
6. Аймаг Шүүхийн тамгын газраас 2025 оны 03 сарын 27-ны өдөр Б.Баттуяа “Эвлэрүүлэн зуучлах” сэдэвт сургалт.


7. УБЕГ-т 2025 оны 03 сарын 31-ээс 04 сарын 01-ний хооронд “Удирдах ажилтаны зөвөлгөөн” хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ, ХЭ,ЭХЭУБТДарга Г.Батсайхан нар оролцсон.
8. АЗДТГ-т 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Удирдах ажилтны зөвөлгөөн”-д ИБТДарга Б.Баттуяа суусан.
9. УБЕГ-ын ЭХЭУБГ болон Монголын нотариатчдын танхимтай хамтарсан цахим сургалтанд “Нотариатчийн цахим системд зуучлалын модул нэвтрүүлэх” 2025 оны 04 дүгээр сарын 05-нд сумын улсын бүртгэгч нар болон ЭХЭУБ-ийн улсын бүртгэгч нар хамрагдсан
10. УБЕГ-ын ИБГаас 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр “Мэдээллийн санд эрх нээх, хаах” сэдэвт сургалт онлайнаар хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ, ИБТДарга Б.Баттуяа нар хамрагдсан.
11. Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр “Даатгуулагчдын зөвлөгөөн”-д нягтлан бодогч У.Буянбат оролцсон.
12. УБЕГ-аас зохион байгуулсан Мэдээлэл технологийн албан хаагчдын нэгдсэн зөвөлгөөнд П.Азжаргал танхимын сургалтанд оролцсон.
13. Мобиком үүрийн телефоноос 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр албан хаагчдад мэдээ мэдээллээр ханган сургалт хийсэн.
14. УБЕГ-т 2025 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн /ахлах/, бүртгэгч нарт зориулсан мэргэжил арга зүйгээр дэмжих сургалтад ИБТДарга Б.Баттуяа, Д.Мөнхцэцэг нарын хамт оролцсон.
15. 2025 оны 05 сарын 17-18-ны хооронд Дорнод аймагт болсон “Мэргэжлийн тасралтгүй хөгжил 2025” зүүн бүсийн салбаруудын мэргэшсэн нягтлан бодогчдын сургалт зөвлөгөөнд оролцсон.
16. Хүний эрхийн үндэсний комиссын Дорноговь аймгийн төлөөлөгч Т.Мөнгөнчулуун “Хүн бүр хүүхэд хамгаалагч” сэдэвт сургалт 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэлийн албан хаагчид хамрагдсан.
17. ХУБ Э.Уранбилэг 2025 оны 06 сарын 6-нд Прокурорын байгууллагын хамтарсан багийн хяналтын улсын байцаагч нарын зөвөлгөөнд оролцсон.



Зураг 1: Хэлтсийн албан хаагчдад Т.Мөнгөнчулуун болон Б.Баттуяа нар танхимын сургалт

Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан сургалт

1. 2025 сарын 03 дугаар сарын 14 өдөр 14 сумын улсын бүртгэгч нарт онлайн сургалт хэлтсийн дарга болон ахлахууд хяналтын улсын байцаагч нарын хамт
2. Дорноговь аймгийн Татварын газарын албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөнд ХЭ,ЭХЭУБДарга Г.Батсайхан, Хуулийн этгээдийн бүртгэгч Ж.Болортуяа, ИБТДарга Б.Баттуяа нар холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээ мэдээлэл хийлээ.



Зураг 2: Дорноговь аймгийн Татварын газарын албан хаагчдын нэгдсэн сургалтанд Б.Баттуяа болон Ж.Болортуяа нар мэдээлэл өгөв

3. 2025 оны 04 дүгээр сарын 09-өөс 11-ний хооронд сумдын бүртгэгч нарт сургалт зөвлөгөөн хийж хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ ИБТДарга Б.Баттуяа, ХЭЭХЭУБТДарга Г.Батсайхан Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг нар сургалт мэдээлэл өгч ажиллаа. Мөн төрийн албаны салбар зөвлөлийн дарга Н.Баттуяа “Төрийн албны ёс зүй”, Тагнуулын мэргэжилтэн Д.Энхбаяр, “Авилгаас урьдчилан сэргийлэх” чиглэлээр ХЗХ мэргэжилтэн Г.Эрдэнэбаяр нар тус тус сургалт өгсөн.

Бусад ажлын хүрээнд

Хууль, зүй дотоод хэргийнсайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг хангаж Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 04 дүгээр сарын 09,10-нд сумын улсын бүртгэгч нарыг, 04 дүгээр сарын 26-нд хэлтсийн албан хаагчид, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг баг бүрэлдэхүүн тус аймагт ирж 2025 оны 05 дугаар сарын 22-нд эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оншилгоонд албан хаагчдыг бүрэн хамруулсан.



Зураг 3: Хэлтсийн албан хаагчид эрт илрүүлэгт хамрагдлаа

“Эрүүл мэнд эрхэм чухал” аяны хүрээнд хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэнд, үзлэг оншилгоонд хамруулсан ажлын үр дүнд үндэслэн “Хөдөлгөөн эрүүл мэнд” өглөөний алхалтын аянг эхлүүлсэн.



Зураг 4: “Хөдөлгөөн эрүүл мэнд” өглөөний алхалтын аян

Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойд зориулсан спортын 4 төрөлт тэмцээнд Зүүн бүсийн аймгуудын баг тамирчид амжилттай оролцож Аймгийн УБХ-ийн архивч Ц.Наранчимэг дартсын төрөлд Алтан медаль, Ахлах бүртгэгч Б.Баттуяа эмэгтэй сагсны төрөлд багаараа алтан медаль тус тус хүртэж нийлбэр дүнгээр 4 дүгээр байрт шалгарлаа.



Зураг 5: УБХ-ийн архивч Ц.Наранчимэг дартсын төрөлд Алтан медаль, Ахлах бүртгэгч Б.Баттуяа эмэгтэй сагсны төрөлд багаараа алтан медаль авлаа

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус байгууллага нь 950 хайлаас тод тарьсан. Үүнд: Дорноговь аймгийн Хамрын хийдийн 3 замын уулзвар Хилэнцэт хөшөөний дэргэд байрлах аялал жуулчлалын бүсийн ногоон байгууламжид 50 хайлаас, Хамрын хийдэд байрлах “Энергийн элс” жуулчны баазад 100 хайлаас, иргэн С.Лхагвасүрэн мөн Д.Золбаяр нарын хашаанд хүлэмжийг тойруулан 800 ширхэг хайлаас мод тус тус тарьсан.



Зураг 6: “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 3 замын уулзвар Хилэнцэт, “Энергийн элс” жуулчны баазад хайлаас тод тарьж байгаа нь